



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/92

Мөрөн сум

Тэжээлийн улаан буудай,
хүнсний тусламж хуваарилах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2024 оны 101 дүгээр тушаал, Аймгийн онцгой комиссын 2024 оны 3 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цас их хэмжээгээр орж өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК аас худалдан авсан малын тэжээлийн улаан буудайг сумдад олгох хуваарийг нэгдүгээр хавсралтаар, Хүнсний дэмжлэгт хамрагдах өрхийн тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Улаан буудай, Хүнсний тусламжийг хүлээн авч, сумдад олгох ажлыг үр дүнтэй, түргэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т, дээрх ажилтай холбоотой шуурхай удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Шуурхай штаб (М.Хуягбаатар)-т, тус тус үүрэг болгосугай.

3. Хүнсний тусламжийг судалгаанд хамрагдсан малчдад хүргэж биелэлтийг тооцон Хүнс хөдөө аж ахуйн газарт 2024 оны 3 дугаар сарын 20 ны өдрийн дотор тайланг ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх) -д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 01-ны өдрийн 42 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

МАЛЫН ТЭЖЭЭЛИЙ УЛААН
БУУДАЙГ СУМДАД ОЛГОХ ХУВААРЬ

Д/Д	Сумын нэр	Малчин өрх, малын тоо			Хэмжээ тн
		Баг	Өрх	Малын тоо	
1	Мөрөн	14	969	239909	5
2	Алаг-Эрдэнэ	5	716	216149	10
3	Арбулаг	6	1010	410352	10
4	Баянзүрх	5	763	362000	5
5	Бүрэнтогтох	6	1032	385563	10
6	Галт сум	5	1185	363818	25
7	Жаргалант	5	1175	246205	25
8	Рашаант	5	634	237037	10
9	Ренчинлхүмбэ	6	1112	193384	10
10	Тосонцэнгэл	6	933	336919	10
11	Төмөрбулаг	5	904	341836	15
12	Түнэл	6	1026	301355	10
13	Улаан-уул	6	853	221678	10
14	Хатгал	0	380	51539	5
15	Цагаан-Уул	6	1280	449841	25
16	Цэцэрлэг	7	913	296753	25
17	Шинэ-Идэр	4	625	214389	15
	Дүн	97	15510	4868727	225

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 01-ны өдрийн 03 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХҮНСНИЙ ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ ӨРХИЙН ТОО

№	Сумын нэр	Нийт өрхийн тоо	Хамрагдах өрхийн тоо	Хамрагдах хувь	Хүнсний бүтээгдэхүүн /тн/		Нийт
					Гурил	Будаа	
1	Шинэ-Идэр	625	625	100	6.3	3.1	9.4
2	Галт	1185	1185	100	11.9	5.9	17.8
3	Жаргалант	1175	1175	100	11.8	5.9	17.6
4	Цэцэрлэг	913	913	100	9.1	4.6	13.7
5	Төмөрбулаг	904	904	100	9.0	4.5	13.6
6	Улаан-Уул	853	853	100	8.5	4.3	12.8
7	Цагаан-Уул	1280	1024	80	10.2	5.1	15.4
8	Ренчинлхүмбэ	1112	890	80	8.9	4.5	13.4
9	Бүрэнтогтох	1032	851	82	8.5	4.3	12.8
10	Баянзүрх	800	400	50	4.0	2.0	6.0
11	Арбулаг	1010	404	30	4.0	2.0	6.1
12	Алаг-Эрдэнэ	716	286	30	2.9	1.4	4.3
13	Рашаант	634	191	30	1.9	1.0	2.9
14	Ханх	435	114	30	1.1	0.6	1.7
15	Тосонцэнгэл	933	280	30	2.8	1.4	4.2
16	Мөрөн	969	291	30	2.9	1.5	4.4
17	Түнэл	1026	380	30	3.8	1.9	5.7
18	Хатгал	414	124	30	1.2	0.6	1.9
19	Цагааннуур	366	110	30	1.1	0.6	1.7
нийт		16382	11000	61	110.0	55.0	165.0

-----oOo-----